



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 07 сарын 30 өдөр

Дугаар А/486

Арвайхээр

Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын
бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг тогтоож, бүтэц, орон тоог хавсралтаар баталсугай.

2. Хуульд заасан эрх хэмжээний дагуу сумын Засаг даргын Тамгын газрын ажилтнуудын ажлын байрны чиг үүргийг тодорхойлон, хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга /С.Хишигдорж/, Засаг даргын Тамгын газрын дарга /Э.Насанцогт/ нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Ц.Ганболд/-т үүрэг болгосугай.

3. Шинээр батлагдсан бүтэц, орон тоог 2018 оны 7 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг сумын Засаг дарга /С.Хишигдорж/-д даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан “Сумдын Засаг даргын Тамгын газрын бүтэц орон тоог шинэчлэн батлах тухай” 2015 оны а/488, “Захирамжид өөрчлөлт оруулах тухай” 2016 оны а/50, “Захирамжид өөрчлөлт оруулах тухай” 2017 оны а/538 дугаар захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101042

Аймгийн Засаг даргын 2018 оны ...07..
 дугаар сарын ...30...-ны өдрийн А/426 дүгээр
 захирамжийн хавсралт

БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН БҮТЭЦ, ОРОН ТОО

Сумдын нэр	Албан тушаалын нэр	Орон тоо
Баян-Өндөр	Засаг дарга	1
	Засаг даргын орлогч	1
	Тамгын газрын дарга	1
	Санхүүгийн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч	1
	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн	1
	Төрийн захиргааны түшмэл	1
	Байгаль орчны хяналтын улсын байцаагч	1
	Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн	1
	Мал аж ахуйн үйлдвэрлэлийн технологи, үржил бүртгэл хариуцсан мэргэжилтэн	1
	Малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн	1
	Бэлчээрийн менежмент, газар тариалан, хоршоо, жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	1
	Нягтлан бодогч	3
	Багийн Засаг дарга	5
	Архив, бичиг хэргийн эрхлэгч	1
	Нярав	1
	Үйлчлэгч	1
	Жолооч	1
Бүгд		23